

..... оны сарын өдрийн Хоршооны тэргүүлэгчдийн хурлын тоот тогтоолоор батлав.

ХОРШООНЫ НӨӨЦИЙН САНГИЙН ЖУРАМ

Хоршооны нөөцийн сан нь үйл ажиллагааны явцад гарч болох болзошгүй эрсдэл, алдагдлаас гишүүдийн хөрөнгийг хамгаалах чухал ач холбогдолтой.

Нөөцийн сангийн хэмжээг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн тогтоож, хоршооны дүрэмд зааж өгөх, өөрчлөх байдлаар зохицуулна.

Нөөцийн сангийн хэмжээ нь жил бүрийн үйл ажиллагааны орлогоос (эсвэлцэвэр орлогоос буюу татвар төлөхийн өмнөх ашгаас) ... хувиар тооцсон дүнтэй байна. Үүний зарчмыг загвар бүдүүвчээр харуулбал:



Нөөцийн сан нь гишүүдэд ноогдол ашгийн хэлбэрээр хуваарилагдах боловч хоршоо үйл ажиллагаагаа зогсоох хүртэл гишүүдэд олгогдохгүй. Хоршооноос гарсан, хасагдсан гишүүдэд нөөцийн хөрөнгөөс ногдох хэсгийг олгохгүй.

Нөөцийн санд хуваарилах хөрөнгийн хэмжээ тогтоосон болон хуваарилагдсан хөрөнгийн бодит хэмжээ нь үйл ажиллагааны орлогын 20 хувиас бага бол түүнийг бүхэлд нь зардлаар тооцон татвар ноогдуулах орлогоос хасаж бүртгэнэ. Харин 20 хувиас хэтрүүлэн нөөцийн сангийн хэмжээг тогтоосон тохиолдолд 20 хувиас илүү гарсан хэсэгт нь татвар ноогдуулж тооцно.

Хоршооны үйл ажиллагаанд алдагдал гарсан үед уг алдагдлыг хоршооны нөөцийн сангаас нөхөж, гишүүдийн хөрөнгийг алдагдлаас хамгаална.

Нөөцийн санд хуваарилагдсан хөрөнгө урт хугацаанд зарцуулагдахгүй, хуримтлал үүссэн үед хоршооны гишүүдэд танилцуулснаар шаардлагатай хөрөнгө оруулалт хийж болно (Эсвэл хөрөнгө оруулалт хийхгүйгээр зөвхөн мөнгөн хэлбэрээр хуримтлуулна).

Нөөцийн сангийн мөнгийг тусгай дансанд байршуулах буюу бэлнээр хадгалах байдлаар бусад хөрөнгөөс тусгаарлаж болно.

Нөөцийн сангийн хөрөнгийг үнэгүйдүүлэхгүйн тулд ханш нь тогтвортой валютын хэлбэрт хөрвүүлж болно.

Нөөцийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэлбэр, өөрчлөлтийн байдалд хоршооны хяналтын зөвлөл хяналт, шалгалт хийж үр дүнгийн талаар бүх гишүүдэд жил бүр мэдээлэн танилцуулж байна.

Хоршооны алдагдлын хэмжээ нөөцийн сангийн 50 хувиас хэтэрсэн үед асуудлыг бүх гишүүдийн хуралд тэр тухайд нь хэлэлцүүлж шийдвэр гаргуулж байна.